

ГАДААД ҮГИЙН БИЧЛЭГИЙГ НЭГ МӨР БОЛГОСОН ТУХАЙ ТЭМДЭГДЭЛ

(Төрийн хэлний зөвлөлийн 2011 оны 10 сарын 05-ны өдрийн “Кирил бичгийн бичлэгийн стандарт тогтоох тухай” тогтоолын тухай)

С. Бат-Эрдэнэ*

Аливаа хэлний үгийн сан бусад хэлний үгийг авч шууд авч хэрэглэх болох орчуулах, утгачлан хөрвүүлэх зэргээр өөриймшүүлэх нь түгээмэл энгийн зүйл болно. Энэ туршид харь хэлний үг авианзүй, үгзүй, утгазүйн талаар тухайн хэлнийхээ өвөрмөц онцлогт дасан зохицож, уугуул гарвалаасаа ихээхэн өөрчлөгдөж болно.

Монгол хэлэнд орсон дорно дахины хэлний үгсийг бичгийн хэлэнд монгол хэлний онцлогт тохируулан буулгах буюу орчуулан хөрвүүлж ирсэн өнийг уламжлал байна. Цөөн хүн бичиг үсэгтэй байсан цагт голдуу ярианы хэлээр орохдоо дуудлага нь ихэд хувьсч, тэр чигээрээ бичигдсээр ирсэн ч байна. Европ хэлнээс монгол хэлэнд орсон үгсийг эрдэмтэд ардын хувьсгалын өмнө ба хойнох (*Б.Рипчен, М.Н.Орловская гэх мэт*) гэж ерөнхийд нь хуваагаад хувьсгалаас өмнө европ үг монгол хэлэнд орсон гүүр нь янз бүрийн, тухайлбал, араб, перс, энэтхэг зэрэг хэл байсан бол хувьсгалаас хойших үед гол гүүр нь орос хэл болсоныг тэмдэглэдэг. Үүгээрээ европын хэлний болон орос үгийг бичихэд орос хэлний зөв бичихзүйг харгалзан авч хэрэглэсэн байна. Гэвч сүүлийн жилүүдэд дэлхийн олон хэлний үг орос хэлний зуучгүй шууд орох, өмнө оросоор дамжсан үгээсээ өөр хувилбар үүсгэх зэрэг хэлний өвөрмөц сонин хууль зүйн үйлчлэлээр тэрхүү уламжлалыг хадгалах аргагүйд хүрч, дээр нь ерөөс нийгмийн шилжилтийн үед гадаад үгийг бичиж тэмдэглэх, дуудах талаар баахан анзаарга муутай орхисноос нийгэмд бухимдал төрүүлэх болоод байгаа. Үүнийг цэгцлэх талаар төр, нийгмийн байгууллага, иргэдийн оролцоотой олон ажил хэрэгжиж байгаагаас, нэн шинэ гэж хэлж болох нэгэн тогтоолын тухай энэ тэмдэглэл-өгүүлэлд авч үзлээ. Энэ тогтоол нь тогтоолын эх, монгол үг, гадаад үгийн бичлэгийг нэр мөр болгох, монголд орчуулан хэрэглэх гадаад хэлний үгсийг үлгэрлэсэн 3 хавсралтаас бүрдэж байна. Бид 2 болон 3 дахь хавсралтыг сонгон авч тусад нь бүлэглэн ажигласнаа хүргэвэл:

Хоёрдугаар хавсралтын эргэн тойронд: “Төрийн албан ёсны хэлний тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.16 дахь хэсэг, “Соёлын тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Кирил бичгийн бичлэгийн стандарт тогтоох мэргэжлийн комиссын дүгнэлтийг үндэслэн, 2011 оны 10 сарын 5-ны өдөр Монгол Улсын Төрийн хэлний зөвлөлөөс гаргасан “Кирил бичгийн бичлэгийн стандарт тогтоох тухай” (Дугаар 01. Улаанбаатар хот) тогтоолд гадаад үгсийг тус тогтоолын 2-р хавсралтын ёсоор, гадаад үгсийн монгол орчуулгыг 3-р хавсралтын ёсоор батлан мөрдүүлэхээр заасан байна. Тус тогтоолын 2-р хавсралтыг ажиглавал, гадаад хэлний үгсийн бичлэгийн нэг мөр

* Москвагийн Их Сургуулийн докторант

болгосон байдал нь европ хэлний голдуу гаралтай харь үгийг бичихэд хэрэглэж ирсэн орос хэлний харь үгийг бичих уламжлалд тулгуурласаар ажээ. Тухайлбал, *автобус, автомат, агентлаг, азот, аккумулятор, актив, альбом, анкет, блиц, бонд, босс, презент, вагон, вальс, валют, газ, гала, дизайн, доллар, какао, караоке, кафе, лазер, лобби, ломбард, модем, онлайн, патент, пицца, покер, радио, робот, саун, сканер, стиль, тариф, факс, фургон, шорт, шоу* зэрэг үгсийг орос хэлний бичлэгийг баримталж ямар ч өөрчлөлтгүй авчээ. Мөн орос хэлний гандбол гэдгээр бичиж, дуудаж байснаасаа татгалзаж, англи хэлний handball гэдэгт ойртуулсан хандбол гэж бичсэн жишээ ч байна. Гэсэн хэрнээ дуудлагыг нь гандбоол гэжээ. Монгол хүн английн уг үгийг эх хэлнээс нь хээндбоол гэж дуудах бөгөөд хэрэв тус хавсралт ёсоор хандбол гэж бичих аваас гандбоол гэж дуудах гэж үгүй, хандбоол л гэж дуудна. Гэхдээ ингэх нь үнэмшил муутай байна. Учир нь хандбол гэсний а эгшгийг тэргүүн үеийн өргөлтийн нөлөөгөөр хаандбоол гэж зөөлрүүлэн дууддаг учраас тэр юм.

Монгол хэлний үсгийн дүрмийн толь (Ц.Дамдинсүрэн, Б.Осор. 1983, хавсралт). Гадаад үг хэрхэн бичих тухай асуудалд (А.Лувсандэндэв, 1959) зэрэг болон дотоод, гадаадын монгол хэл судлаач эрдэмтдийн бүтээлд монгол хэлний авиа зүй, үг зүйн онцлогийн дагуу харь үгийг хэрхэн бичиж байгаа болон бичих боломжийн талаар авч үзсэн байдаг.

Тус тогтоолын 2-р хавсралтад кирилл гэх үгийг кирил гэж бичсэн хэрнээ өөр энэ мэт нэг тогтолцоотой бичигдэх үгсийг анзаараагүй байна. Акад. А.Лувсандэндэв “монгол бичигт урт гийгүүлэгчийг тэмдэглэдэггүй бөгөөд хоёр ижил гийгүүлэгч хойно өмнөө эгшиггүй нэг дор ордоггүй. Ийм учраас гадаад үгэнд хоёр ижил гийгүүлэгч хойно өмнөө эгшиггүй нэг дор ордог нь үсгийн дүрмийг зөрчиж байгаа зүйлийн нэг байна. Учир иймээс гадаад үгийн хойно өмнөө эгшиггүй нэг дор орсон хоёр ижил гийгүүлэгчийг нэгээр бичиж болох юм” (2002:303) гээд, кросс гэхийг крос, процесс гэхийг процес, балл гэхийг бал, ватт гэхийг ват, хлорофилл гэхийг хлорофил гэж бичиж болохыг заасан. Үүгээр дээрх тогтоолын 2-р хавсралт дахь кирилл гэхийг кирил гэж, сканнер гэхийг сканер, эссе гэснийг эсээ гэсэнтэйгээ адилаар үлдсэн үгс болох баррел гэдгийг барел, босс гэдгийг боос, гамма гэдгийг гама, грамм гэдгийг грам, доллар гэдгийг долар, инноваци гэдгийг иновац, концесс гэдгийг концес, мессеж гэдгийг мессеж, мисс гэдгийг миис, пицца гэдгийг пиица, процессор гэдгийг процесор, ралли гэдгийг раалий, теллер гэдгийг телер, терроризм гэдгийг тероризм, троллейбус гэдгийг тролейбус, целлойд гэдгийг целойд гэх зэргээр бичих хэрэгтэй болно.

Хэл бол дохио тэмдэгийн тогтолцоо мөн, Хэл бол хүмүүсийн харилцааны гол хэрэгсэл болно гэсэн алдартай томъёоллыг их сургуулийн хэлний ангийн нэгдүгээр ангийн оюутанд хүртэл албадан сургадаг байтал бүх нийтийн хэлний бичлэгийг жигдлэхээр гаргасан энэхүү сайхан санаачлагатай ажилд тун бага анхаарсан шиг санагдана. Хэл дохио тэмдэгийн тогтолцоо болох нь аливаа хэлний үсгийн дүрмийн тогтолцоот чанарыг сайжруулахад эхэлж бодох зүйл зайлшгүй мөн. Хэл хүмүүсийн харилцааны гол хэрэгсэл болох нь үсгийн дүрмийн хэрэглээтэй шууд холбогдоно. Нэг нь хүн гэж бичээд, нөгөөх нь хун гэж бичээд байвал хэл гэдэг утга чанараа алдах юм. Өөрөөр хэлбэл, үсгийн дүрмийн журамлах чадал нь тогтолцоон дээр суурилж хэрэгжинэ.

Мөн акад. Ц.Дамдинсүрэнгийн үсгийн дүрмийн тольд “Оросоор ия үсгээр төгссөн үгийн эцсийн ия үсгийг их төлөв хасна. Жишээлбэл, Румыния-Румын, станция-стани, комиссия-комисс, лекция-лекц гэх мэт. Гэвч ия үсгээр төгссөн зарим үгийн

эцсийн гийгүүлэгч зөөлөрсөн байвал зөвхөн я үсгийг хасна. Жишээлбэл: Азия-Ази, Италия-Итали гэх мэт" (1983:422) гэж заасан. Үүгээр бол инноваци гэснийг инноваци гээд дээр дурдсан хоёр гийгүүлэгч нэг дор орохгүйгээр иновац гэж болох байна. Мөн академи гэдгийг академ гэж болно. Тус тогтоолын 2-р хавсралтад корпораци гэдгийг корпорац, радиаци гэдгийг радиац, презентаци гэдгийг презентац гэж бичсэн хэрнээ бусад адил бичигдэх үгсэд энийгээ баримтлаагүй байна. Радиац, троллейбус гэсэн бичлэг ч гэсэн монгол хэлний авиазүйн бүрхүүлд орж, авиазүйн онцлог хуулийн дагуу зохицон өөрчлөгдөх ёстой. Тухайлбал, монгол хэлэнд үгийн эхэнд -р гийгүүлэгч ордоггүй, өмнөө эгшиг жийрэглэдэг болон үгийн тэргүүн үед давхарласан гийгүүлэгч ордоггүй, дунд нь эгшиг жийрэглэдэг ёсоор ардиац, торлейбус болох юм. Энэ ёсыг баримталж, дурдаж буй тогтоолын 2-р хавсралтад рама гэдгийг араам гэж бичихээр тусгажээ. Гэтэл үүнийгээ жигд баримталсангүй, юунаас ч юм "хулчийжээ". Эндээс тус тогтоолын хавсралтыг боловсруулсан этгээд тохиолдлын чанартай оноолт хийсэн нь мэдэгдэнэ. Уг нь энэ сайхан санаачлагатай ажилд илүү нухацтай, ул суурьтай, тогтолцоотой, урдах хойдохоо харж хандах байж.

Энэ нь эрт үед монгол хэлэнд орсон үгийг кирил үсгээр бичихэд ч хамаарах л зүйл. Тухайлбал, одоо рашаан, равдан гэж бичиж сурсан нь угтаа аршаан, аравдан гэж хэлэгдэж, дуудагдах ёстой байтал рашаан, равдан гэж бичээд, өмнө нь эгшиг жийрэглэн дуудаж байгаа нь хэлний тэмдэгийн тогтолцоот чанарыг бодсон хэрэг. Соч, слайд гэж бичихийг искооч, ислайд гэж бичвэл монгол хэлний ёсонд дөхөм боловч хүн хүний өвөрмөц дуудлага хийгээд нутгийн аялгууны онцлогоор олон хувилбар үүсч болох магадтайг бодож уг хэвээр бичиж байгаа болно. Нэг нь искооч, эскооч, эшкооч гээд нөгөө нь шокооч гэж ярих нь хэлний ерийн үзэгдэл бөгөөд зайлшгүй байх зүйл.

Тогтоолын хавсралтад гадаад үгийн дуудлагыг хадахыг оролджээ. Гэвч хэлшинжлэлийн ямар үндэслэлээр, зөв дуудахуйн ямар шалгуураар энэ дуудлагыг тогтоон хадсан нь бас л тодорхойгүй. Тухайлбал, библи гэсэн үгийн дуудлага нь бийбли юм гэнэ. Би л лав бийбэл юмуу бийбил гэж дуудах бөгөөд бусад монголчууд ч мөн тэгдэг байх гэж найдна. Монгол хэлнүүдийн авиазүйн хууль ч үүнийг батална. Монгол хүн Ли гэж бичих ахул хятад хүн овог, нэрийг заасан үг гэж ойлгохын дээр Лий гэж уртаар дуудахаас Ли гэж огцом дуусгахгүй. Мөн академи гэдгийн дуудлага нь монгол хүнд бараг ак(а)дийм гэсэнтэй ойр хэлэгдэхээс бус эгшиг зохицох ёстой монгол хэлэнд академи гэж нэг үгэнд гурван өөр авиаг хэлэх гэж бүр байхгүй хэрэг. Тус тогтоолын хавсралтад үгийн дуудлага гэж бифштекс (бифштекс), буфеэд (буфет), вектор (вектор), валеэнт (валент), жеэндэр (жендер) зэргээр бичсэн нь урт жагсаалт боллоо. Энэ нь монгол хэлний авианзүйд суурилсан зөв дуудахзүйн ёсыг зөрчиж байна.

Дуудлагын хувилбар олон янз байхын шалтгаан нь яс, үндэсээс гадна өгүүлэхийн эрхтний хөгжил, насны байдал, хүйс, боловсролын нөлөө хүртэл байж болно. Гэхдээ өөрийн хэм хэмжээтэй гэдэг нь дээрх жишээнээс тод харагдаж байна. Харин бичгийн хэл, утга зохиолын хэлний нэгдмэл байх тухай яриа бол огт өөр зүйл. Үүнийг хангахад ярианы болон нутгийн аялгууны хэл, буриад, халимаг зэрэг төрөл хэлний туршлага тун их хэрэгтэй боловч эцсийн хувилбарыг нэг л маягаар журамлан тогтоох нь зөв. Үүний нэг баталгаа бол дэлхийн англи хэлээр ярилцагч бүхий л ард түмний хэл, аялгуу, олон янз дуудлагаас үл хамааран, тус хэлний үсгийн дүрэм хөдөлбөргүй хэдэн зуун жилийг үдсэн явдал мөн. Монгол хэл нэгэн цагт одоогийн

англи хэлний үүргийг гүйцэтгэж байсныг бодож, яваандаа мөн гүйцэтгэх юм шиг санаж хариуцлагатай хандах нь зүйтэй.

Монгол хэлэнд харь үг олон янзаар бичигдэж байгаа учир шалтгааны талаар зохиогчоос *“Харь үг, нэр томъёоны тухай”* (Нэр томъёо судлал. №9. Уб., 2007:26) гэсэн өгүүлэл нийтлүүлж байсан билээ. Тус өгүүлэлд монголоор ёворцог гэсэн утгатай билярд хэмээх үгийн толь бичиг, ном, сэтгүүл, сонин, хаяг, сурталчилгаанаас олсон 11 хувилбарыг, өөр өдий төдий үгийн хувилбаруудтай танилцуулсан болно. Харь үг олон янзаар бичигдэхийн шалтгаан нь зөв бичихзүй буюу үсгийн дүрмийн толиуд харилцан зөрүүтэй хэвлэх, нийтийн мэдээллийн хэрэгслүүд янз бүрээр хэрэглэх, боловсрол мэдлэггүйгээсээ ард иргэд андуу ташаа бичих зэрэг олон байдлаар гарсан юм.

Гуравдугаар хавсралтын эргэн тойронд: Энэ хавсралт нь Монголоор орчуулан хэрэглэх гадаад хэлний үгс гэсэн нэртэй юм. Цөөн хэдэн үгийг жишээ болгон үзүүлсэн нь бодвол тун олон янзаар бичигдэж, орчуулагдаж, нийгэмд төвөг яршиг болсон “нөхөд” бололтой. Гэвч ажиглахад тийм биш юм. Тухайлбал, эдэн дунд варени (*варенье*)-чанамал, микр (*микро*)-бичил, потенциал-чадамж, сюрприз-гэнэтийн бэлэг зэргээр хэдийн монголчуудад танил болсон үгс байж байна. Эднийг аль эрт орчуулан хэрэглэсэн нь, харин ч зарим нь бүр гадаад үгийг шахан түрж, орон зайг нь эзлэн авсан үгс байх юм. Тухайлбал, варени-чанамал гэдэг үгийн варени нь ярианы хэлэнд үлдэж, бичгийн хэлэнд чанамал нь нэгэнт хэвшсэн бол микр-бичил гэсэн үгийн микр нь жижиг оврын автобус, бичил нь байрны цомхон хорооллыг заан хэрэглэгдэж хэвшсэн тул бичил автобус гэж хольж хутгаж ярихгүй, гагцхүү ярианы хэлэнд микр хороолол гэх нь цөөн боловч тохиолдож байна.

Тус хавсралтад гадаад үгийн нэгэнт хэвшсэн орчуулгыг эвдсэн жишээ байна. Тухайлбал, бялдаржуулах урлаг гэж хэвшээд байгаа бодибилдингийн бялдаржуулал гэжээ. Тийм байж болноо гэвэл, өгүүлбэрзүйн түвшинд очихоороо бялдаржуулах урлагийн буюу бодибилдингийн аварга шалгаруулах тэмцээн гэсэн холбоо үгийг бялдаржууллын аварга шалгаруулах... гэсэн дотно биш хувилбараар солих аж. Мөн үүнтэй адил жишээ, брэнд гэдгийг сор (*бүтээгдэхүүн*) гэж орчуулахаар заасан байна. Сайхан сонсогдож магад. Гэтэл алдарт Пума брэндийн хувцасаар гангарах гэхийг Пума сор бүтээгдэхүүнээр (*эсвэл зүгээр л сороор*) гангарах гээд солиод найруулахаар утга нь нэг л бууж өгөхгүй байна. Нийслэлд Нэрийн барааны дэлгүүр гэж байсан нь угтаа үйлдвэрийн буюу брэнд бүтээгдэхүүний дэлгүүр юм. Сор бүтээгдэхүүн заавал брэнд байх албагүй учраас утгын талбайд орон зайн, чиг үүргийн зөрчил үүсгэж байна. Ярианы хэлэнд Панасоник нэрийн өнгөт зурагт гэхчилэн ярьдагаар нэрийн... (*цэгийн оронд тохирох төрлийг сонгоно*) гэж орчуулж болохгүй гэж үү.

Бонус гэхийг урамшуулал гэж нэлээд дөхүү орчуулсан атлаа хаалтанд цалин гэж гэж тодотгосон нь юу илэрхийлж байгаа нь тодорхойгүй, урамшуулал цалин гэж холбогдох аваас үүнийг шагналын цалин, нэмэгдэл цалин гэж л хэлдэг. Бонус дангаараа цалингаас өргөн олон төрлийн урамшуулалд хамаарна. Ледеринийг хиймэл арьс гэж орчуулахаар заажээ. Технологийн нарийн ялгааг гаргаж чаддаг болсон энэ үед ледерин нь нэг янз материал, хиймэл арьс нь нэг янз, бүр арьс орлохуйц материалыг заах болсон гэж үйлдвэрлэлийн бус мэргэжилтэн би санана. Монголчуудын нийтлэг аж ахуй болох дэлгүүр, мухлагт түгээмэл ашигладаг манекенийг загвар өмсгүүр гэсэн байна. Ц.Дамдинсүрэн нарын *“Орос-монгол толь”* (1982)-д уг үгийг *“хувцас тааруулан оёхын тулд хүний биеийн хэмжээгээр хийсэн модон хүн, хиймэл хүн”* гэж тайлбарлажээ. Одоо энэ зүйл заавал модон байх албагүй болсоноос гадна, хувцас өмсгөж хүмүүст

харуулах хэрэгсэл болоод шинэ утгаар баяжсан байна. Өмсгүүр гэсэн үгийг бүтээсэн – уур² дагаврын хувьд ямар үг бүтээдэг болохыг нь авч үзье.

Цохиур, даллуур, нүдүүр, баллуур, алчуур (*арчуур*), хадуур зэрэг шууд язгуураас үүссэн үгсээс гадна хутгуур, цутгуур, тосгуур гэсэн нь хэлбэрийн хувьд өмсгүүртэй төстэй харагдаж байгаа ч бүтцийн хувьд хутга-уур, цутга-уур, тос-(g)уур (*монгол бичгийн хэлэнд tosu язгуурт –иur дагавар залгахад нэг төрлийн эгшиг нэг дор хоёроос дээш давхарлан орохгүй тул нэг нь хэлэхүйн явцад хураагдсан буюу г гийгүүлэгчээр орлуулагдсанаас үүдэлтэй*) гэж задардаг нь өмс-өмсгө-өмсгүүр гэсэн загвар байхгүйг харуулна. Энэ загвараар үг бүтээвэл хий-хийлгэ-хийлгүүр, гүй-гүйлгэ-гүйлгүүр, шах-шахуул-шахуулгуур гэсэн юм болох биз. Үг бүтэх ёсыг зөрчсөн үгээр орчуулгад стандарт тогтоожээ гэж үзэхээр байна.

Наалтууз (*скоч*) гэсэн орчуулга ч эргэлзээ төрүүлж байна. Уран хараацай гэж хоёр үгийг хураангуйлан ураацай гэж үүсгэдэг уламжлалын дагуу наадаг тууз, наах тууз гэж үг нийлж үүссэн гэж үзвэл наалтууз гэсний л гийгүүлэгч хаанаас гарч ирсэн хэрэг болох вэ. –лт дагавраар үүсч байна гэж үзвэл, наа- гэсэн язгуураас наалт, наалдац, наалдамтгай, наанги зэрэг үүр үг үүсэх боломжтой байдаг. Монгол хэлний нэр үг бүтээх хамгийн бүтээцтэй дагаврын нэг болох –лт дагавраар бүтсэн бусад үгсэд –ууз төгсгөл залгавал, цохилтууз, таталтууз, даралтууз гэсэн хачин, утга учиргүй цэс үүсгэж болох юм. Ердөө дагавраар үг бүтээхэд нэр үгээс дахин нэг үүрэгтэй дагавраар нэр үг үүсгэх бараг боломжгүй. Энэ нь зарим эрдэмтдийн элэг доог болгон жишээлдэг, ходоодтос, нүдтэс, ажилбар гэсэн жишээ шиг зүйл болно.

Эцэст нь үгийг оноон орчуулахдаа тусгай мэргэжлийн ойлголт, мэдлэгийг харгалзах хэрэгтэй байна. Тухайлбал, стресс гэдгийг сэтгэлийн бухимдал, дарамт гэсэн байна. Стресс гэвэл заавал бухимдалаар илрэх үү, дарамтаас үүдэлтэй юм уу гэдгийг лавлах л хэрэг. Продюсор гэдгийг кино бүтээгч гээд ахиад л гадаад үг оролцуулан орчуулж. Энэ бага хэрэг гэтэл кино хамтын бүтээл болохоор түүнийг бүтээдэг олон хүн, тухайлбал, зохиолч, зураглаач, зураач, жүжигчид гээд цөм продюсер үү гэж хэн ч асуух зүйл. Үүнийг уг нь бид найруулагч гэж орчуулан хэрэглэдэг нь буруу юм гэж үү. Сүүлийн үед монгол хэлэнд орсон гадаад үгийн толь, тухайлбал, Н.Балжиннямын тольд, продюсер гэхийг уран сайхны найруулагч гээд орчуулсан нь бас л тохиромжгүй юү.

Дүгнэлт

Монгол хэлний кирил бичлэгийн стандарт тогтоох нь нийгэм, соёл, боловсрол, шинжлэх ухааны өргөн талбарт зайлшгүй шаардагдаж буй чухал ажил мөн. Нэн ялангуяа дэлхий нийтэд нээлттэй ардчилсан Монгол улсын хувьд дэлхийн хэл соёлтой харилцан хаяа нийлж, золголдон учирах өнөө, ирээдүйд үндэсний хэл, соёлын дархлаагаа хадгалан сайжруулах бодлого, тогтолцоо нэн тулгамдсан хэрэг болж байна. Үүнийг шийдвэрлэхээр холбогдох байгууллагуудаас хийж буй энэ алхамыг сайшаалтай. Гэлээ ч хэлний тухай хууль тогтоомж, тогтоол, тушаал бол олон нийтийн оролцоо, зохион байгуулалтыг шийдэх зам болохоос хэлний хөгжлийг хувьсган өөрчлөх боломжгүй. Ерөнхий болон эх хэлний хууль зүй, тогтолцоог сайтар мэдэх нь, хэл хоорондын харилцан холбоо, нөлөөлөл, тухайлбал, харь хэл соёлын нөлөөг тусган авах болон өөриймшүүлэн авахад гол үндэс болох бөгөөд үүнийг орхигдуулах буюу дутуу хагас ашиглах нь энэ мэт сайхан ажлыг чанаргүй, үнэ цэнгүй болгож болно. Тогтоолын хавсралт бол уг ажлыг хэрэгжүүлэх үлгэр загвар болох тул алдаа мадагтай

байх нь ихээхэн хор хохиролтой бөгөөд дор хаяж, хуучин гарсан тайлбар толь, харь хэлний толь, хоёр хэлний толь, зөв бичих зүйн толь болон мэргэжлийн бусад суурь мэдлэгийг ашиглах, мэргэжилтнийг хангалттай зохион байгуулж оролцуулах нь дараа дараагийн ажилдаа бодох зүйл байна.

НОМ ЗҮЙ

1. Балжинням Н. (2008) *Монгол хэлний гадаад үгийн толь*. -311 т, Улаанбаатар..
2. Бат-Эрдэнэ С. (2007). *Харь үг, нэр томъёоны тухай*. // *Нэр томъёо судлал*. №9. х.26. Улаанбаатар.,
3. Дамдинсүрэн Ц., Осор Б. (1983) *Монгол үсгийн дүрмийн толь*. 430 т. Улаанбаатар.,
4. Орловская М.Н. (1961) *Имена существительные и прилагательные в современном монгольском языке* -116 стр. Москва.,
5. Лувсандэндэв А. (1959) *Гадаад үг хэрхэн бичих тухай асуудалд*. –*Монгол хэл бичгийн тухай зарим асуудал*. х.68-76, Улаанбаатар.,
6. *Монгол үндэсний утга зохиолын хэл бүрэлдэн тогтсон нь*, (2002) х.303-312, Улаанбаатар.,
7. Ринчен Б. (2011) *Латин, грек, орос хэлний гаралтай үгийн угтвар, дагаврыг дүйлгэн орчуулах тухай*. // Б.Ринчен. *Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган*. I боть. х.100-111. Улаанбаатар.,
8. Төрийн хэлний зөвлөлийн 2011 оны 10 сарын 05-ны өдрийн “*Кирил бичгийн бичлэгийн стандарт тогтоох тухай*” тогтоолын эх.